

**ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2022 ОНЫ
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА, АЙМГИЙН 80 ЖИЛИЙН ОЙН БАЯР НААДМЫН
ХАНДИВЫН ЗАРЦУУЛАЛТАНД ХЯНАЛТ ШАЛГАЛТ
ХИЙСЭН ТУХАЙ ТАНИЛЦУУЛГА**

2022.12.23

Нэг. Хяналт шалгалтын зорилго:

Монгол улсын “Төрийн хяналт шалгалтын тухай хууль”, “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль”, “Төсвийн тухай хууль”-уудын хүрээнд аймгийн ЗДТГ-ын 2022 оны санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, Монгол улсын “Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль” болон бусад холбогдох хууль тогтоомж тэдгээрт нийцүүлэн гаргасан эрх зүйн акт заавар журам, норм нормативын хэрэгжилтэнд хяналт шалгалт хийж үнэлэлт дүгнэлт өгөхөд шалгалтын зорилго оршино.

Хоёр. Шалгалтын бүрэлдэхүүн, хугацаа:

Шалгалтыг “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль”, Дундговь аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны 2022 оны санхүүгийн хяналт шалгалтын төлөвлөгөөний дагуу 2022 оны 11 сарын 06 өдрийн 19 тоот удирдамжаар санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагч С.Бархасмаа, санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагч Б.Батсайхан нар санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд, хяналт шалгалтыг 2022 оны 11 дүгээр сарын 07-оос ажлын 7 хоногийн хугацаанд хийхээр төлөвлөсөн.

Сангийн яамнаас Монгол улсын Засгийн газрын 2020 оны 211 тогтоолоор айл өрх, албан байгууллага, аж ахуйн нэгжид цахилгаан, дулаан, уур ус, хогны үнийн хөнгөлөлт үзүүлсэнтэй холбоотой үйлчилгээ үзүүлсэн аж ахуйн нэгжийн хөнгөлөлт, чөлөөлөлт, үйлчилгээний төлбөрийг нэхэмжилсэн тооцоог шалгах удирдамжаар шалгалт хийгдэх, зургаан сумдад төлөвлөгөөт хяналт, шалгалтыг яаралтай хийхээр шийдвэрлэснээр тус шалгалтын хойшлуулан 12 сарын сард хийж дуусгалаа.

Гурав. Хамрагдсан асуудал

Шалгалтыг тус байгууллагын 2022 оны санхүү, аж ахуйн үйл ажиллагааны холбогдох баримтанд тулгуурлан төсөвт байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг шалгаж үнэлэлт дүгнэлт өгснөөс гадна дараах чиглэлээр тодотгож хийсэн. Үүнд:

1. Санхүү, төсөв, нягтлан бодох бүртгэл тухайн байгууллагатай холбоотой хууль, тогтоомж, дүрэм журам, хамтын гэрээ, үйл ажиллагаандаа мөрдөж буй бусад эрхийн актын хэрэгжилт

2. 2022 оны 11 дүгээр сар хүртлэх төсвийн хөрөнгийн захиран зарцуулалт, анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт, санхүүгийн тайлан гаргалтын байдал.

3. Харилцах болон бэлэн мөнгөний зарцуулалтын анхан шатны баримтын бүрдүүлэлт, хууль эрх зүйн үндэслэл, зарцуулалтын байдал

4. Төсвийн хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөр, хандив зээл тусламжийн эх үүсвэрээр бий болсон хөрөнгийн баримтийн бүрдүүлэлт, зарцуулалт тэдгээрийг нягтлан бодох бүртгэлд тусгасан байдал

5. Ажиллагсадын цалин тогтоомж, тооцоололт, олголтын баримтын бүрдэл

6. Өмч хөрөнгийн бүртгэл, хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт, тооллого, тооцоо бодолт

7. Өр авлагын барагдуулалт үүссэн өр авлагыг нягтлан бодох бүртгэлд тусгасан байдал

8. Иргэн, аж ахуйн нэгж байгууллагатай байгуулсан гэрээ түүний хэрэгжилтийг дүгнэсэн байдал

9. Өмнө хийгдсэн шалгалтын зөвлөмжийн дагуу хийгсэн ажлын тайлан, төлбөр барагдуулалтын байдал

10. Шилэн дансны тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 29 тоот тогтоолоор баталсан “ Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам”-ын дагуу цахим сүлжээнд байршуулсан мэдээллийг үндсэн баримт материалтай нь тулган шалгах.

Дөрөв. Шалгалтанд хамрагдсан объектын талаарх товч мэдээлэл:

Аймгийн Засаг дарга бүрэн эрхээ хэрэгжүүлэх нөхцлийг бүрдүүлэхэд Тамгын газрын үйл ажиллагааг мэргэшлийн үндсэн дээр удирдан зохион байгуулж, Засаг даргыг мэргэшлийн цаг үеэ олсон эцсийн шатны бодлогын зөвлөгөө, бүх талын дэмжлэгээр шуурхай хангах замаар Тамгын газрын үйл ажиллагааны үр дүн бүтээмжийг дээшлүүлэх.

Дараах үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлийг хэрэгжүүлж байна.

1. Аймгийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааг мэргэшлийн үндсэн дээр удирдах

2. Нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн стратеги, бодлого, хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулалтаар хангах, хяналт шинжилгээ, үнэлгээ хийх замаар хэрэгжилтийг хангуулах.

3. Сумдын засаг даргын Тамгын газар, Засаг даргын дэрэгдэх хэрэгжүүлэгч агентлагын үйл ажиллагааг удирдах, зохицуулалтаар хангаж ажиллах.

4. Нутгийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагын манлайлалыг хангах

5. Байгууллагын төсвийг үр ашигтай захиран зарцуулах, санхүүгийн удирдлагыг хэрэгжүүлэх.

6. Засаг даргаас шилжүүлсэн бусад бүрэн эрхийг хэрэгжүүлэх, шаардлагатай зөвлөгөө мэдээллээр хангах.

Дээрхи зорилтыг хэрэгжүүлэхийн тулд Монгол улсын Төсвийн тухай хуулийн 16.4.18-д заасны дагуу тус байгууллагын 2022 оны харилцахын баримтанд дараах албан хаагчид нэг, хоёр дугаар гарын үсэг зурсан байна.

	хугацаа	
1 гарын үсэг	2022.01.01-одоог хүртэл	Л.Доржбат
2 гарын үсэг	2022.01.01- 2022.02.28	М.Янжиндолгор
2 гарын үсэг	2022.03.01- 2022.09.30	Н.Энхмарт
	2022.10.01- одоог хүргэл	М.Янжиндолгор

ЗДТГ-ын даргын 2022 оны 1 дүгээр сарын 24 өдрийн Б/06 тоот тушаалаар албан цалин нэмэгдэл баталсан байна. Үүнд Засаг дарга 1, орлогч дарга 1, төрийн захиргааны 34, төрийн тусгай 3, төрийн үйлчилгээний 25 орон тоотой ажиллаж байна. Албан тушаалын цалинг оны эхэнд баталж, нэмэгдэл урамшуулалыг хуулийн дагуу олгосон байна.

2022 оны 3-р улирлын санхүүгийн тайлангаар:

Тайлант хугацаанд 3,802,056.2 мянган төгрөгийн төлөвлөгөөт санхүүжилтыг авч үйл ажиллагаандаа зарцуулан тайлагнасан. харилцах дансагд 468,985.2 мянган төгрөг, 224,571.6 мянган төгрөгийн авлагтай, 12,922.9 мянган төгрөгийн өглөгтэй тайлагнасан байна.

Үндсэн хөрөнгийн тайланд эхний үлдэгдэл 16,958,807.7 мянган төгрөг тухайн онд худалдан авсан хөрөнгө 7,000.0 төгрөг, хандив тусламж, үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгө 789,290.5 мянган төгрөг байна.

Бараа материалын тайлангийн эхний үлдэгдэл 256,429.5 мянган төгрөг өөрийн хөрөнгөөр 366,082.9 мянган төгрөг, хандиваар 3,992.4 мянган төгрөгийн бараа, материал худалдан авч орлогодсон байна. Зарцуулсан бараа материалын үнэ 280,164.8 мянган төгрөг буюу эцсийн үлдэгдэл 346,340.0 мянган төгрөгөөр тайлагнагджээ.

Баланс 2022 он:

Эргэлтийн хөрөнгийн дүн	Үүнээс				Эргэлтийн бус хөрөнгө	Үүнээс							Нийт хөрөнгийн дүн	Өглөг	Засгийн газрын сан	Өр төлбөр, эзний өмчийн дүн
	Мөнгөн хөрөнгө	Авлага	мал амьтан	Хангамжийн материал		Барилга, байгууламж	Авто тээврийн хэрэгсэл	Машин, тоног төхөөрөмж	Тавилга, аж ахуйн эд хөрөнгө	Биет бус хөрөнгө	НОМ	Бусад				
1,039,896,9	468,985.2	224,571.6	0	346,231.6	11,787,911.5	8,595,668.4	561,050.0	862,532.8	454,190.4	3,359,045.0		3,622,119.3	12,827,808.5	12,922.9	5,297,821.9	12,825,550.5

Тав. Өмнөх шалгалтын талаар:

2020 онд албан хаагч нарт албан томилолтоор ажиллах хугацаанд албан томилолтын зардал, цалингийн сангаас хоолны мөнгийг давхардуулан олгосон зөрчилд 1,045.1 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоосон байна. /Хэрэгжсэн/

Батлагдсан цалингийн сан, бүтэц орон тоонд байхгүй, тухайн албан тушаалтны чиг үүрэгт заагдсан ажлыг хэрэгжүүлж байгаа төрийн захиргааны албан хаагчдад ажил хавсран ажилсан нэмэгдэлийг ЗДТГ-ын дарга, Хүний нөөцийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн, Хөдөлмөр, нийгмийн хамгалалын бодлого хариуцсан мэргэжилтэн, Санхүү төрийн сангийн хэлтэсийн дарга, нягтлан болох бүртгэлийн мэргэжилтэн нарт сар бүр тухайн албан хаагчийн үндсэн цалингийн 20-30 хувиар олгосон 7,605.7 мянган төгрөгийн зөрчилд хугацаатай албан шаардлага хүргүүлсэн байна. /Дутуу хэрэгжсэн/

Төрийн аудитын газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар “ЗӨРЧИЛГҮЙ” санал дүгнэлт авсан байна. Тус аудитаар 664,868.1 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс аудитын явцад 618,837.5 мянган төгрөгийн алдааг залруулж, 978.0 мянган төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт, 45,052.6 мянган төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага, 1 зөвлөмж хүргүүлсэн байна.

Зургаа. Шалгалтын явцад хийгдсэн ажил, шийдвэрлэсэн асуудал

Дотоод хяналт шалгалтын тогтолцоо, түүний үйл ажиллагааны талаар:

Монгол улсын “Төрийн хяналт шалгалтын тухай хууль”-ийн 13.1-д байгууллага, аж ахуйн нэгжийн эрх баригч нь холбогдох хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газар, түүний байгууллага, тухайн хурал, Засаг даргын болон өөрийн шийдвэрийг байгууллагынхаа хэмжээнд хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, дотоод

хяналт шалгалтын журам тогтоож ажиллана, “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль”-ийн 67.1-д төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч нь өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдалд өдөр тутам тавих дотоодын хяналтыг зохион байгуулж, түүний үр дүнг төрийн өмнө хариуцна, “Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль”-ийн 18-р зүйлд нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтыг хэрэгжүүлэх талаар заасан заалтын дагуу хийсэн ажил болон дотоод хяналтын нэгжийн тайлан ирүүлээгүй.

Батлагдсан төсөвт санхүүжилтийн талаар:

Тус байгууллагын дүнгээр 2021 оны 3-р улиралын байдлаар нийт 1,835,639.8 мянган төгрөгийн төсөвт зардал батлагдсанаас гүйцэтгэлээр 1,497,605.0 мянган төгрөгийн зардал гаргаж төсөвт зардлыг батлагдсан хэмжээнээс 338,034.7 мянган төгрөгөөр хэмнэсэн байна.

2022 онд нийт 2,005,256,3 мянган төгрөгийн төсөвт зардал батлагдсанаас гүйцэтгэлээр 1,725,285,1 мянган төгрөгийн зардал гаргаж төсөвт зардлыг батлагдсан хэмжээнээс 279,971,1 мянган төгрөгөөр хэмнэсэн байна.

ЗАРДЛЫН АНГИЛАЛ	2021 ОНЫ				2022 ОНЫ				Төлөвлөгөө өсөлт /+/, бууралт -/	Гүйцэтгэл өсөлт /+/, бууралт -/
	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Өөрчлөлт		Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Өөрчлөлт			
			ДҮН хэмнэлт -, хэтрэлт +	Хувь			ДҮН хэмнэлт -, хэтрэлт +	Хувь	Мөнгөн дүнгээр	Мөнгөн дүнгээр
Үндсэн, нэмэгдэл цалин	714,826,300	692,920,727	21,905,573	3.1	572,627,800	565,135,428	7,492,372	1.31	142,198,500	1,258,056,155
Нийгмийн хамгааллын шимтгэл	89,292,500	84,212,144	5,080,356	5.7	73,864,300	64,879,810	8,984,490	12.16	15,428,200	149,091,954
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	134,386,800	130,116,022	4,270,778	3.2	132,963,700	132,963,700	-	-	1,423,100	263,079,722
Хангамж, бараа материалын зардал	59,538,800	51,002,443	8,536,357	14.3	83,000,200	67,037,252	15,962,948	19.23	(23,461,400)	118,039,695
Эд хогшил Урсгал засвар	69,645,100	35,600,327	34,044,773	48.9	53,031,000	27,942,736	25,088,264	47.31	16,614,100	63,543,063
Томилолт	43,500,000	26,635,610	16,864,390	38.8	40,240,400	31,531,000	8,709,400	21.64	3,259,600	58,166,610
бусдаар гүйц а.үйлгн	8,500,000	5,500,940	2,999,060	35.3	21,841,600	18,599,000	3,242,600	14.85	(13,341,600)	24,099,940
Даатгалын үйлчилгээ	5,000,000	4,192,750	807,250	16.1	4,166,700	4,166,700	-	-	833,300	8,359,450
Тээв/хэр. татвар	650,000	377,190	272,810	42.0	708,300	-	708,300	100.00	(58,300)	377,190
Тээв/хэр. Оношлогоо	300,000	143,000	157,000	52.3	143,300	128,300	15,000	10.47	156,700	271,300
мэдээллийн технологийн зардал	2,000,000	788,000	1,212,000	60.6	3,433,300	2,871,000	562,300	16.38	(1,433,300)	3,659,000
газрын төлбөр	550,000	-	550,000	100	208,300	-	208,300	100.00	341,700	-
бараа үйлчилгээ зардал	32,000,000	556,350,749	(524,350,749)	-1638.6	21,500,000	13,149,798	8,350,202	38.84	10,500,000	569,500,547
Гэрээгээр гүйцэтгэх	15,663,700	15,663,700	-	0	337,463,200	284,753,896	52,709,304	15.62	(321,799,500)	300,417,596
Бусад зардал	400,000	400,000	-	0					400,000	400,000
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	82,000,000	17,392,520	64,607,480	78.7896	32,553,500	27,675,020	4,878,480	14.99	49,446,500	45,067,540
төрөөс иргэдэд олгох					16,511,800	16,511,800	-	-	(16,511,800)	16,511,800
		126,851,009								
Бусад	9,930,000		9,930,000	100	8,517,100	8,517,100	-	-	1,412,900	8,517,100
Урсгал зардал	566,178,300		566,178,300	100.0	791,719,700	627,495,046	164,224,654	20.74	(225,541,400)	627,495,046
Баяр наадам	8,778,300	-	8,778,300	100					8,778,300	-
НИЙТ ЗАРЛАГА	1,835,639,800	1,497,605,067	338,034,733		2,005,256,300	1,725,285,151	279,971,149		(169,616,500)	(227,680,084)

Нэмэлт санхүүжилтийн талаар:

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасан байдаг.

2022 оны 10 дугаар сарын байдлаар нэмэлт санхүүжилтийн дансанд нийт 1,893,861.5 мянган төгрөгийн орлого орж ирснээс тухай бүр зардлын зүйлүүдэд зарцуулах эрх нээлгэн зарцуулсан байна. Үүнд: Төрийн албаны зөвлөлөөс, Миг даатгалаас, урьд оны үлдэгдэл 303,558.9 мянга, Архивын үндэсний төвөөс, НҮБ-ийн сургалтын санхүүжилт, Мал хамгаалах сангийн ажилтны цалин, худаг ажиллуулсны орлого 147,778.4 мянга, Аймгийн 80 жилийн ой зохион байгуулах баяр наадмын хандивын үйл ажиллагаанд 1,442,524.2 мянган төгрөгийн хандивын орлогыг хүлээн зөвшөөрч 1,672,190.4 мянган төгрөгийг зарцуулан үлдэгдэл 22,167.1 мянган төгрөг байна. Үлдэгдлийг задалбал: Хандив тусламжийн орлогын үлдэгдэл 179,288.1 мянга, урьд оны үлдэгдэл 40,106.2 мянга, архивын орлогын үлдэгдэл 2,277.1 мянган төгрөг байна.

Шилэн дансны мэдээлэл:

Шилэн дансны тухай хуулийн дагуу төсвийн болон улс, орон нутгийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор төсвийн удирдлагын шийдвэр, үйл ажиллагааны ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, түүнд олон нийтийн хяналт тавих мэдээллийн тогтолцоог хуулийн дагуу хангасан талаар хяналт хийхэд 2021 онд 128 мэдээлэл байршуулахаас 128 мэдээлэл байршуулж 2 мэдээлэл хугацаа хоцроосон биелэлт 100 %, байна. 2022 онд 122 мэдээлэл байршуулахаас 122 мэдээлэл байршуулж биелэлт 100 %, байна.

№	Төсөвт байгууллагын нэр	Төсөв/ гүйцэтгэл			ХО, тендер, ху/авалт			Бусад			Дүн			Бүгд мэдээлэл зохих	Мэдээлсэн	хэрэгжилт %
		хугацаандаа	Хоцроосон	мэдээллээгүй	хугацаандаа	Хоцроосон	мэдээллээгүй	хугацаандаа	Хоцроосон	мэдээллээгүй	хугацаандаа	Хоцроосон	мэдээллээгүй			
2021	Аймгийн ЗДТГ	20	0	0	42	0	0	64	2	0	126	2	0	128	128	100
2022		22	0	0	42	0	0	64	0	0	122	0	0	122	122	100

Үндсэн хөрөнгийн хөдлөлийн талаар

АЗДТГ нь 2021 оны эхэнд нийт 15,805,386.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгөтэй, 2022 оны мөн үед 16,358,807.7 мянган төгрөгийн хөрөнгө бүртгэж 553,421.6 мянган төгрөгөөр нэмэгдэж хөрөнгийн өсөлт 2021 оны 9 сарыг 2022 онтой харьцуулбал 3 хувиар өссөн байна.

Он	Барилга	Авто-машин	Тоног техөөрөмж	Аж ахуйн эд хогшил	Бусад	програм хан	бусад биет хөр бус	ДҮН	Хөрөнгийн өсөлт мян.₮	Өсөлт /Хувиар/
2021.09.30-ний үлдэгдэл	8,161,839,287	651,050,000	783,984,119	379,348,676	115,908,977	89,371,100	5,623,884,000	15,805,386,159	553,421,632	3
Орлого			7,299,900	9,930,000				17,229,900		
Зарлага		90,000,000						90,000,000		
ХЭ оны эхний үлдэгдэл	354,748,454	370,986,110	685,014,199	190,420,091	46,025,608	89,371,100		1,736,565,562		
Элэгдлийн зардал	169,999,620	53,631,249	28,466,026	27,801,753	14,914,927			294,813,575		
Нийт	7,637,091,213	226,432,641	77,803,794	171,056,832	54,968,442	-	5,623,884,000	13,791,236,922		
2022.09.30-ний үлдэгдэл	8,611,990,390	561,050,000	854,793,637	454,190,444	163,528,220	89,371,100	5,623,884,000	16,358,807,791		
Орлого	258,819,339		7,739,200		10,000,000	1,500,000	518,232,000	796,290,539		
Зарлага	275,141,279						2,784,396,000	3,059,537,279		
Зарлага	16,321,940									
ХЭ оны эхний үлдэгдэл	581,414,615	352,494,444	694,398,702	217,461,823	47,376,935	89,371,100	3,357,720,000	5,340,237,619		
Байгуулсан элэгдэл	188,185,429	53,631,249	43,918,486	39,413,219	16,130,431	175,000		341,453,814		
Нийт	7,842,390,346	154,924,307	124,215,649	197,315,402	110,020,854	1,325,000	3,357,720,000	11,787,911,558		
Хөрөнгийн цэвэр дүн	8,870,809,729	561,050,000	862,532,837	454,190,444	173,528,220	90,871,100				
2 жилийн нийт зарлага	291,463,219	90,000,000					2,784,396,000	3,165,859,219		
2 жилийн нийт орлого	258,819,339		15,039,100	9,930,000	10,000,000	1,500,000	518,232,000	813,520,439		

Бараа материалын хөдлөлийн талаар

Бараа материал 2021 оны 09-р сарын 30-ны байдлаар 239,856,.9 мянган төгрөгийн үлдэгдэлтэй, 2022 оны 09 сарын байдлаар 370,075.4 мянган төгрөгийн бараа материалын орлого авч, 280,164.8 мянган төгрөгийн бараа материал зарцуулсан 346,340.0 мянган төгрөгийн бараа материалын үлдэгдэлтэй байна.

Он	тусгай зориулалт	эм боох мат	Бичиг хэргийн материал	Аж ахуйн материал	Сэлбэг хэрэгсэл	Түлш шатах тослох материал	барилга засвар	хүнс	Бусад	ДҮН	Хөрөнгийн өсөлт мян.₮	Өсөлт %/
2020.06.30-ний үлдэгдэл	108,480		5,806,225	220,962,213	2,923,800	7,258,000		1,090,000		238,148,718	106,483,160	30
Орлого			5,007,500	59,041,923	11,836,700	19,292,029	8,693,940	8,569,700		112,441,792		
Зарлага			5,553,700	49,472,518	11,836,700	26,112,029	8,693,940	9,064,700		110,733,587		
2021.09.30-ний үлдэгдэл	108,480		5,260,025	230,531,618	2,923,800	438,000		595,000		239,856,923		
Орлого			6,139,000	244,487,610	6,511,650	68,382,345	6,668,750	5,886,090	32,000,000	370,075,445		
Зарлага			5,914,450	157,287,265	6,694,800	65,894,257	6,532,750	5,841,340	32,000,000	280,164,862		
2022.09.30-ний үлдэгдэл	108,480		5,048,395	333,620,680	1,691,850	5,094,928	136,000	639,750		346,340,083		
Хөрөнгийн цэвэр дүн												
2 жилийн нийт зарлага			11,468,150	206,759,783	18,531,500	92,006,286	15,226,690	14,906,040	32,000,000	390,898,449		
2 жилийн нийт орлого			11,146,500	303,529,533	18,348,350	87,674,374	15,362,690	14,455,790	32,000,000	482,517,237		

**Байгууллага, хүмүүстэй хийх тооцоо өр,
авлагын баталгаажуулалт, өсөлт бууралтын талаар**

Тус байгууллагын хэмжээнд авлага 2021.9.30-ний байдлаар 121,069.6 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байсан бол 2022.09.30-нд 224,571,6 мянган төгрөг болж өссөн, 2021.09.30-ний байдлаар 1,268.0 мянган төгрөгийн өглөгтэй байсан бол 2022.09.30-нд 12,922.9 мянган төгрөгийн өглөгтэй болж нэмэгдсэн байна.

ӨГЛӨГИЙН ТАЙЛАН				
ҮЗҮҮЛЭЛТ	ОНУУД		2021-2022	
	2021.09	2022.09	Өсөлт +, бууралт -	Хувь
Эхний үлдэгдэл	1,268,000	209,436,748	208,168,748	165
АЗДТГ			-	
Эцсийн үлдэгдэл	1,268,000	12,922,936	11,654,936	101
АВЛАГЫН ТАЙЛАН				
Эхний үлдэгдэл	121,069,631	239,097,310	118,027,679	197
АЗДТГ				-
Эцсийн үлдэгдэл	134,034,727	224,571,626	90,536,899	167

Долоо. Шалгалтаар илэрсэн зөрчил, зөрчигдсөн хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар:

1. Баяр наадмын хандивын орлогыг 10,154.700 төгрөгөөр дутуу тайлагнасан. Мөн сумдаас хандиваар ирсэн 230 хонь, 5 ямаа, 15 адуу, 6684 литр айраг, 432 кг ааруул, 122 кг бяслаг, 16.8 кг ээзгийг бүртгэл, тайланд тусгаагүй. Төсвийн тухай хуулийн 6.3.4-т *“төсвийн жилийн явцад шинээр бий болсон аливаа орлого, эх үүсвэр, зээл, хандив, тусламж, тэдгээрээр санхүүжүүлсэн үйл ажиллагааны зарлага нь төсвийн бүрэлдэхүүн байх”*, Сангийн сайдын 2006 оны 11 дүгээр сарын 27 өдрийн 388 тоот тушаалын хавсралт 1-ийн 2.12-т *“Хэрэв буцалтгүй тусламжийн орлогыг хөрөнгө тухайлбал, бараа материалаар хүлээж авсан бол гэрээнд заасан эсвэл зах зээлийн үнээр бүртгэнэ.Дт. Бараа материал Кт. Тусламжийн орлого”* гэсэн заалтуудыг зөрчсөн.

2. Баяр наадмын үйл ажиллагаанд зориулан 27,421.357 төгрөгийн шатахууны зардал гаргасан боловч жолоочийн тооцоо бодоогүй, талон тараасан жагсаалт байхгүй, гадны жолоочтой гэрээ байгуулаагүй. НББ-ийн тухай хуулийн 13.7-т *“Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”*, 13.4-т *“Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна”*, гэсэн заалтуудыг зөрчсөн.

3. Баяр наадмын зардал болох 94,892.3 мянган төгрөгийн бараа материалыг шууд зардлаар тайлагнаж, хяналтгүй зарцуулсан. Төсвийн тухай 16.5.2-т *“батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих”*, НББ-ийн тухай хуулийн 13.7-т *“Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”*, 13.4-т *“Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна”*, 14.4-т *“Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал*

бүртгээнэ:14.4.1.аж ахуйн бүх ажил, гүйлгээ”, 14.4.2-т “бүх хөрөнгөө, хөрөнгөө оруулалт, авлага”, 14.4.3-т “бүх өр төлбөр”, 14.4.4-т “аж ахуйн үйл ажиллагааны санхүүгийн эх үүсвэр”, 14.4.5-т “бүх орлого”, 14.4.6-т “бүх зардал”, заалтуудыг зөрчсөн.

Шалгагдагч байгууллагын тайлбар:

Аймгийн 80 жилийн ойн баяр наадмын хандивын үйл ажиллагааны санхүүжилтийг ил тод нээлттэй хараа хяналттай байлгах үүднээс ЗДТГазрын нэмэлт санхүүжилтийн данс, арилжааны банк дах кассын дансуудаар дамжуулан зохион байгуулахаар шийдвэрлэн Аймгийн Засаг даргаар захирамжаар батлуулсан. Мөн 2022 оны 6 дугаар сарын 23 өдрийн А/162 тоот ЗДТГазрын даргын тушаалаар байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт нэмэлт оруулах тухай шийдвэр гарган өөрчлөлт оруулсан.

Үүнд: СТОУС-15 орлого хүлээн зөвшөөрөлт-Байгууллагын үндсэн үйл ажиллагаатай хамааралгүй, аймаг орон нутгийн шинжтэй арга хэмжээний хандив тусламжийн бэлэн мөнгөний орлогыг нэмэлт санхүүжилтийн данс, кассын харилцах дансуудаар хүлээн авч, уг асуудалтай холбогдуулан байгуулсан ажлын хэсэг, комиссын батлагдсан төсвийн хүрээнд зарцуулах

СТОУС-12 Бараа материал-Байгууллагын үндсэн үйл ажиллагаатай хамааралгүй, аймаг орон нутгийн хэмжээний нэг удаагийн шинжтэй арга хэмжээний зохион байгуулалтын хүрээнд бий болсон бараа, материал, эргэлтийн шинжтэй хөрөнгийг уг асуудалтай холбогдуулан байгуулсан ажлын хэсэг, комисс хүлээн авах, зарцуулах бөгөөд үлдэгдэл хөрөнгийг Аймгийн ЗДТГазарт хүлээлгэн өгч орлогод авах

Иймд тухайн дансаар дамжаагүй өөр дансанд орлогоор бүртгэгдсэн орлогыг хандивт тусгаагүй, комиссуудын хүлээн авсан хөрөнгийг чанартай бараа материалыг орлого, зарлагад хүлээн зөвшөөрөөгүй үлдэгдлийг хүлээн зөвшөөрч тайлагнасан.

Шийдвэрлэлт: Цаашид зөрчлийг арилгах, дахин давтахгүй байх талаар зөвлөмж өгөгдсөн.

Мөн нэмэлт санхүүжилтын данснаас санхүүжүүлэгдсэн Аймгийн 80 жилийн ойн баяр наадмын үйл ажиллагаатай холбоотой гэрээ дүгнээгүй, бараа материал орлогодоогүй, анхан шатны баримтыг зохион байгуулагчдаас бүрдэл дутуу авч санхүүгийн баримтанд үдсэн байсан шалтгааныг үндэслэн гэрээг дүгнэсэн акт үйлдсэн, үлдэгдэл хөрөнгийг орлогоор тусгасан орлогын баримт, хөрөнгө тараасан жагсаалтаар баталгаажуулсан 474,365.7 мянган төгрөгийг зөрчлийг шалгалтын явцад залруулсан.

Найм. Авсан арга хэмжээ, мэргэжил арга зүйн зөвлөгөө:

Шалгалтын удирдамжийг байгууллагын удирдлага, санхүү, бүртгэлийн ажилтнуудад танилцуулж, шалгалтыг холбогдох нягтлан бодогчийг байлцуулан үндсэн баримтанд тулгуурлан явуулж, зөрчилтэй зүйлүүдэд тухай бүр нь хууль, тогтоомжийн үндэслэлийг нь тайлбарлан зөвлөн туслав. Байгууллагын дарга Л.Доржбат нягтлан бодогч Н.Энхмарт, М.Янжиндолгор нарт хууль тогтоомжийн талаар зөвлөн туслаж, хамтран ажиллалаа.

Ес. Шалгалтаар өгсөн дүгнэлт

Аймгийн АЗДТГ нь 27.4 хувьтай дунд эрсдэлтэй.

№	ҮЗҮҮЛЭЛТ/ЗДТГазар /	Өгвөл зорих оноо	ДҮГНЭЛТ					
			Шаардлага бүрэн хангасан (5)	Шаардлага сайн хангасан (4)	Шаардлага дунд хангасан (3)	Дутагдалтай (2)	Хангалтгүй (1)	
1	Нягтлан бодох бүртгэлийн бодлоготой эсэх, түүний чанар	5	5					
2	Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулж ажилласан	5				2		
3	Нягтлан бодох бүртгэл хөтлөлтийн хэлбэр	5	Гараар					
			Программаар	5				
4	Нягтлан бодох бүртгэлийн хөтлөлтийн хувь	5	100	95.0 – 99.9	90.0 - 94.9	85.0 – 89.9	84.9 доош	
				4				
5	Анхан шатны бүртгэлийн хөтлөлтийн хувь	5	100	97.0 – 99.9	93.0 -96.9	90.0 – 92.9	89.9 доош	
							1	
6	Санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал	5		4				
7	Өмч хөрөнгийн ашиглал, шамшигдал гаргасан	5	Гараагүй	50,0 мян₮ хүртэл	500.0 мян₮ хүртэл	501.0 – 1000.0 мян₮ хүртэл	1000.0 мян₮ -нөөс дээш	
			5					
8	Төсвөөс (төрөөс) гарахгүй зардалд зориулалт бусаар хөрөнгө зарцуулсан	5	Зарцуулагүй	1000,0 мян₮ хүртэл	1001-2000,0 мян₮ хүртэл	2001-3000,0 мян₮ хүртэл	3001 мян ₮-өөс дээш	
				4				
9	Батлагдсан төсөвт зардлын гүйцэтгэл	5	Хэмнэгдсэн	Хэтрээгүй	2.5 хүртэл % хэтэрсэн	2.6 – 7.5 хүртэл % хэтэрсэн	7.6-аас дээш % хэтэрсэн	
				4				
10	Өглөгийн өсөлт, бууралт (өмнөх онтой харьцуулснаар)	5	ӨГЛӨГГҮЙ	ӨМНӨХ ОНООС БУУРСАН		ӨМНӨХ ОНООС ӨССӨН		
				50.0 дээш хувь	50.0 доош хувь	50.0 доош хувь	50.0 дээш хувь	
11	Авлагын өсөлт, бууралт (өмнөх онтой харьцуулснаар)	5	АВЛАГАГҮЙ	ӨМНӨХ ОНООС БУУРСАН		ӨМНӨХ ОНООС ӨССӨН		
				50.0 дээш буурсан	50.0 доош	50.0 доош	50.0 дээш	
12	Өмч хөрөнгийн ашиглалт, хамгаалалт	5	Онц	Сайн	Дунд	Муу	Маш муу	
			5					
13	Шалгалтаар илэрсэн санхүүгийн зөрчил	5	Зөрчилгүй	500,0 мян ₮ хүртэл	501-1500 мян ₮	1501-2000 мян ₮	2001 мян ₮-нөөс дээш	
							1	
14	Өмнөх шалгалтын актын хэрэгжилт /хувиар/	5	100	95.0-99.9	90.0-94.9	70.0 - 85.9	70.0 доош	
			5					
15	Өмнөх шалгалтын зөрчлийн давтагдал	5	Давтагдалгүй	1 – 2 давтагдсан	3 - 4 давтагдсан	5-6 давтагдсан	6-гаас дээш	
				4				

16	Худалдан авах ажиллагааны журмыг зөв сонгосон	5	5				
17	Санхүүгийн хууль эрхийн мэдлэг	Дарга	5			3	
18		Ня-бо	5			3	
19		Нярав	5			3	
ОНООНЫ ДҮН			95	30	20	9	6
ДУНДАЖ ХУВЬ			27.4				

ӨГСӨН ҮНЭЛГЭЭ

ДУНД ЭРСДЭЛТЭЙ

Арав.Шалгагдсан байгууллагад өгсөн дүгнэлт шийдвэрлэвэл зохих асуудлууд:

Тус байгууллага нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулан байгууллагынхаа санхүүгийн үйл ажиллагаанд мөрдөн, санхүүгийн программ ашиглан ажилладаг.

Анхан шатны баримтын бүрдэлгүй, гарын үсэг, тамга, тэмдэгээр баталгаажуулаагүй гүйлгээ хийгдсэн, төрийн сангийн хяналт муу, анхан шатны бүртгэл хөтлөлт хангалтгүй, хандив тусламжийн орлого дутуу тайлагнасан, хандивын орлогыг хяналтгүй зарцуулсан зэрэг зөрчил нь “шаардлагын түвшинд хүрэхгүй, санхүүгийн үйл ажиллагаагаа сайжруулах шаардлагатай, дунд эрсдэлтэй” байна гэж дүгнэлээ.

Арван нэг. Цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар өгсөн зөвлөмж

1. Төсвийн тухай хуулийн 16.5.5 батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах

2. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1.Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно, 13.5.Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно, 13.6.Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна, 13.7.Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалтуудыг мөрдлөгө болгон ажиллах.

3. Төсвийн тухай хуулийн 6.3.4-т “төсвийн жилийн явцад шинээр бий болсон аливаа орлого, эх үүсвэр, зээл, хандив, тусламж, тэдгээрээр санхүүжүүлсэн үйл ажиллагааны зарлага нь төсвийн бүрэлдэхүүн байх”, Сангийн сайдын 2006 оны 11 дүгээр сарын 27 өдрийн 388 тоот тушаалын хавсралт 1-ийн 2.12-т “Хэрэв буцалтгүй тусламжийн орлогыг хөрөнгө тухайлбал, бараа материалаар хүлээж авсан бол гэрээнд заасан эсвэл зах зээлийн үнээр бүртгэнэ.Дт. Бараа материал Кт. Тусламжийн орлого” гэсэн заалтуудыг мөрдөж хандив тусламжийг санхүүгийн тайланд бүрэн тусгаж байх

4. Төсвийн тухай 16.5.2-т “батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих”, 13.4-т “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна”, 14.4-т “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ:14.4.1.аж ахуйн бүх ажил, гүйлгээ”, 14.4.2-т “бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт,

авлага”, 14.4.3-т “*бүх өр төлбөр*”, 14.4.4-т “*аж ахуйн үйл ажиллагааны санхүүгийн эх үүсвэр*”, 14.4.5-т “*бүх орлого*”, 14.4.6-т “*бүх зардал*”, заалтуудыг хэрэгжүүлэн ажиллах

Шалгалтаар илрүүлсэн алдаа, зөрчлийг дахин давтан гаргахгүй байх, зөвлөмжийн хэрэгжилтийг 2023 оны 03 дугаар сарын 15-ний дотор Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанд албан тоотоор хариу ирүүлэх, эрсдлийг бууруулсан байх.

ХЯНАСАН:

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ДОТООД АУДИТЫН
АЛБАНЫ ДАРГА: С.ЭНХЖАРГАЛ

ТАНИЛЦУУЛГА БИЧСЭН:

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ: С.БАРХАСМАА

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
УЛСЫН БАЙЦААГЧ: Б.БАТСАЙХАН

ТАНИЛЦСАН:

ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГА: Л.ДОРЖБАТ

НЯГТЛАН БОДОГЧ: М.ЯНЖИНДОЛГОР

НЯГТЛАН БОДОГЧ: Н.ЭНХМАРТ

